

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2023/19/НА-СТА-ЗГНС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261628 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг Утас: 261740 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Аудитор: О.Баярмаа Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn Аудитор: Д.Болормаа Утас: 261740 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТЦЭЦЭГ
ТАНАА

2023. 03.24 № 01/682
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албыг татан буулгаж, сангийн албан хаагчдын гүйцэтгэж байсан ажлыг яамны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу холбогдох албан хаагчдад хуваарилан гүйцэтгүүлж байна.

Аудитын гол асуудал

Тус сангийн төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 4,161,442.2 мянган төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 6,408,259.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагуудаас авах өмнөх оны 954,353.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан мөн тайлант онд шинээр 8 байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч болсноос 4,600.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн зэргээс голлон нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2022 онд хэрэгжүүлэхээр тусгасан Монгол Улсын хэмжээнд алслагдсан орон нутгийн бүсэд зайлшгүй шаардлагатай

Z:\Yawsan_Bichig\2023\0324 SNAG-4.Docx

0001051321

хөдөлгөөнт холбооны үйлчилгээ, интернэтийн үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ, харилцаа холбооны дэд бүтэц зэрэг 5 чиглэлээр 8 төсөл, арга хэмжээг 87.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,898,380,949.77	21,436,920,690.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,809,313,009.23	6,964,010,442.94
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,809,313,009.23	6,964,010,442.94
31210	Төгрөг	3,809,313,009.23	6,964,010,442.94
31211	Төрийн сангийн харилцах	3,809,313,009.23	6,964,010,442.94
33	АВЛАГА	1,635,108,000.54	680,754,965.79
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,601,604,400.75	679,289,439.36
33500	Бусад авлага	33,503,599.79	1,465,526.43
33510	Байгууллагаас авах авлага	33,503,599.79	1,465,526.43
35	БАРАА МАТЕРИАЛ	1,188,000.00	861,000.00
35400	Хангамжийн материал	1,188,000.00	861,000.00
35420	Аж ахуйн материал	-	861,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,188,000.00	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	11,452,771,940.00	13,791,294,281.75
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	11,452,771,940.0	13,791,294,281.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,841,834.54	13,592,829.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,841,834.54	13,592,829.74
39200	Биет хөрөнгө	7,027,155.28	13,304,500.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,600,000.00	9,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(34,515,723.76)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	13,135,100.00	9,572,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,570,606.98)	(5,767,599.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,173,554.00	1,859,164.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,795,167.98)	(1,859,164.00)
39300	Биет бус хөрөнгө	814,679.26	288,329.26
39301	Програм хангамж	2,631,750.00	2,631,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,817,070.74)	(2,343,420.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,906,222,784.3	21,450,513,520.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,446,804,972.70	2,380,845,926.19
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,446,804,972.70	2,380,845,926.19
41300	Өглөг	362,178,583.24	578,289,158.84
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	130,669,434.30	-
41360	Бусад өглөг	231,509,148.94	578,289,158.84
41361	Байгууллагад төлөх өглөг	231,509,148.94	578,289,158.84
41400	Урьдчилж орсон орлого	3,084,626,389.46	1,802,556,767.35
41440	Бусад урьдчилж орсон орлого	3,084,626,389.46	1,802,556,767.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,459,417,811.61	19,069,667,594.03
51	Засгийн газрын хувь оролцоо	13,459,417,811.61	19,069,667,594.03
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	23,293,144.00	23,293,144.00
51200	Хуримтлагдсан үр дүн	13,428,522,547.96	19,046,374,450.03
51210	Өмнөх үеийн үр дүн	8,625,622,683.83	13,016,296,234.16
51220	Тайлант үеийн үр дүн	4,802,899,864.13	6,030,078,215.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,602,119.65	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,906,222,784.31	21,450,513,520.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,040,298,488.66	7,092,142,551.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,039,178,488.66	7,092,142,551.31
120	Нийтлэг татварын бус орлого	5,039,178,488.66	7,092,142,551.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,039,178,488.66	7,082,642,551.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,039,178,488.66	7,082,642,551.31
120009	Бусад орлого	-	9,500,000.00
13	Тусламж санхүүжилтийн орлого	1,120,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,120,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,120,000.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	237,398,624.53	1,062,064,335.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	237,398,624.53	1,062,064,335.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	231,349,550.53	1,062,064,335.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,691,339.30	35,144,531.23
210102	Нэмэгдэл	149,459,339.30	31,272,531.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	3,872,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,244,980.32	3,613,935.77
210201	Тэтгэврийн даатгал	15,790,880.32	2,457,476.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,613,400.00	289,114.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,290,800.00	216,836.13
210204	Ажилгүйдлийн даатгал	322,600.00	72,278.71
210205	Эрүүл мэндийн даатгал	3,227,300.00	578,229.69
2104	Хангамж, бараа материалын зардал	8,817,421.16	11,289,225.00
210401	Бичиг хэрэг	1,833,900.00	1,539,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,156,000.00	6,114,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	874,752.16	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,952,769.00	1,133,825.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,501,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,136,200.00	380,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,136,200.00	380,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,966,250.00	1,659,600.00
210702	Дотоод албан томилолт	18,966,250.00	1,659,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,517,890.45	1,006,228,038.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764,914.45	1,006,228,038.64
210803	Даатгалын үйлчилгээ	89,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	572,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,975,469.30	3,749,004.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,975,469.30	3,749,004.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,049,074.00	-

2132	Бусад урсгал шилжүүлэг	4,929,074.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,929,074.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,120,000.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,120,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,802,899,864.13	6,030,078,215.87
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,802,899,864.13	6,030,078,215.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,842,108,605.32	10,474,544,690.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,840,988,605.32	10,474,544,690.81
120	Нийтлэг татварын бус орлого	6,840,988,605.32	10,474,544,690.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,750,340,079.32	10,217,572,466.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,750,340,079.32	6,408,259,457.14
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	3,809,313,009.23
120009	Бусад орлого	90,648,526.00	256,972,224.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,120,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,120,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,120,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,158,490,497.48	3,510,534,247.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,158,490,497.48	3,510,534,247.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,867,341.78	3,510,534,247.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,691,339.30	34,030,678.11
210102	Нэмэгдэл	149,459,339.30	30,158,678.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	3,872,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,244,980.32	3,613,935.77
210201	Тэтгэврийн даатгал	15,790,880.32	2,457,476.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,613,400.00	289,114.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,290,800.00	216,836.13
210204	Ажилгүйдлийн даатгал	322,600.00	72,278.71
210205	Эрүүл мэндийн даатгал	3,227,300.00	578,229.69
2104	Хангамж, бараа материалын зардал	10,135,465.16	10,033,797.00
210401	Бичиг хэрэг	1,833,900.00	2,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,464,000.00	4,680,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	874,752.16	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,962,813.00	2,793,797.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,567,400.00	1,653,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,567,400.00	1,653,400.00
2107	Томилолт, зочны зардал	18,966,250.00	1,659,600.00
210702	Дотоод албан томилолт	18,966,250.00	1,659,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,165,156.00	3,454,970,542.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,412,180.00	3,454,970,542.99
210803	Даатгалын үйлчилгээ	89,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	572,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,096,751.00	4,572,294.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,096,751.00	4,572,294.00

212	ТАТААС	2,906,574,081.70	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,906,574,081.70	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,906,574,081.70	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,049,074.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,929,074.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,929,074.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,120,000.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,120,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		6,964,010,442.94
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		6,964,010,442.94
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
21	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,964,010,442.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	13,459,417,811.61	13,459,417,811.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(443,121,577.45)	(443,121,577.45)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00		13,016,296,234.16	13,016,296,234.16
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	13,016,296,234.16	13,039,589,378.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,293,144.00		13,016,296,234.16	13,039,589,378.16
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			6,030,078,215.87	6,030,078,215.87
D09	2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	23,293,144.00	-	19,046,374,450.03	19,069,667,594.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,161,442,200.00	3,475,037,733.63	686,404,466.37	83.5
УРСГАЛ ЗАРДАЛ	4,161,442,200.00	3,475,037,733.63	686,404,466.37	83.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,161,442,200.00	3,475,037,733.63	686,404,466.37	83.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,876,800.00	34,030,678.11	141,846,121.89	19.3
Нэмэгдэл	152,644,800.00	30,158,678.11	122,486,121.89	19.7
Унаа хоолны хөнгөлөлт	23,232,000.00	3,872,000.00	19,360,000.00	16.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,984,600.00	3,613,935.77	18,370,664.23	16.4
Тэтгэврийн даатгал	14,949,500.00	2,457,476.44	12,492,023.56	16.4
Тэтгэмжийн даатгал	1,758,800.00	289,114.80	1,469,685.20	16.4
ҮОМШӨ-ний даатгал	1,407,000.00	216,836.13	1,190,163.87	15.4
Ажилгүйдлийн даатгал	351,800.00	72,278.71	279,521.29	20.5
Эрүүл мэндийн даатгал	3,517,500.00	578,229.69	2,939,270.31	16.4
Хангамж, бараа материалын зардал	17,460,000.00	10,033,797.00	7,426,203.00	57.5
Бичиг хэрэг	2,560,000.00	2,560,000.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	9,500,000.00	4,680,000.00	4,820,000.00	49.2
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,600,000.00	0.00	2,600,000.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,793,797.00	6,203.00	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.00	1,653,400.00	7,846,600.00	17.4
Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.00	1,653,400.00	7,846,600.00	17.4
Томилолт, зочны зардал	21,602,800.00	1,659,600.00	19,943,200.00	7.6
Дотоод албан томилолт	20,345,500.00	1,659,600.00	18,685,900.00	8.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,257,300.00	0.00	1,257,300.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,907,018,000.00	3,424,046,322.75	482,971,677.25	87.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,904,100,000.00	3,424,046,322.75	480,053,677.25	87.7
Даатгалын үйлчилгээ	198,000.00		198,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	198,000.00		198,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00		22,000.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500,000.00		2,500,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00		1,500,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00		1,500,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00		6,500,000.00	-
Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,500,000.00		6,500,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00		6,500,000.00	-

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00		6,500,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	6,408,259,457.14	-6,408,259,457.14	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,161,442,200.00	6,408,259,457.14	-2,246,817,257.14	154.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,161,442,200.00	6,408,259,457.14	-2,246,817,257.14	154.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	6,964,010,442.94	-6,964,010,442.94	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,422.5 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад залруулаагүй алдааг арилгах 1 зөвлөмж өглөө.

3.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Урьдчилж орсон орлого дансны эхний үлдэгдлээс 79 байгууллагын 16,422.5 мянган төгрөгийг тооцоо нийлээгүй, тайлант жилийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.	1	16,422.5			1	16,422.5			1	16,422.5	1	16,422.5
Дүн	1	16,422.5			1	16,422.5			1	16,422.5	1	16,422.5

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52,115.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, алдааг засах 1 зөвлөмж өгсөн.

3.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэр бүхий 74 аж ахуйн нэгж байгууллагын 2008-2019 онд үүссэн, 3-аас дээш жилийн насжилттай 301,515.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэйгээс, 5,325.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 3 ААНБ нь улсын бүртгэлд байхгүй, 175,846.5 мянган төгрөгийн 50 ААНБ-ын харилцаа холбооны тусгай зөвшөөрөл цуцлагдсан.	1	-			1	-				
2	Бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй, нэр бүхий 30 аж ахуйн нэгж байгууллагын 2008-2020 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон 8,420,595.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	-			1	-				
3	Барьцааны өглөгийн дансанд хуримтлагдсан 5-аас дээш жилийн насжилттай, нэр бүхий 4 аж ахуйн нэгж байгууллагын нийт 52,115.2 мянган төгрөгийн өглөгийг барагдуулахаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.	1	52,115.2			1	52,115.2				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4	Орлого бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч 230 байгууллагаас 70 байгууллага орлого төвлөрүүлээгүй байна. Тайлант онд 98 хуулийн этгээд хуульд заасан хугацааг хоцроож орлого төвлөрүүлсэн байна. 	1	-			1	-					
Дүн		4	52,115.2			4	52,115.2			-		

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил² илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудаст тайлант онд мэдээлэх 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	-						1	-
Дүн		-						1	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.